



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Оюуны ирээдүй” цогцолбор сургуулийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/116/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2024 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

_____ № _____
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Оюуны ирээдүй “цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Оюуны ирээдүй “цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 6 сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд, ерөнхий боловсролын сургуулиудад сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэж, Боловсролын ерөнхий газрын санхүүжилтээр мөн цахим, дижитал 2 ангийг тайлант онд нээн ажиллуулсан байна.

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Оюуны ирээдүй “цогцолбор сургуулийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний нийт төсвийн гүйцэтгэл 92.65 хувийн биелэлттэй байна.

Аудитын гол асуудал

Засгийн Газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240, 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоож, Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/109 тоот тушаалаар сургалтын байгууллагын

гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшуулалд нийт багш, ажилчдыг хамруулан олгохоор шийдвэрлэсэн байна

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори "Оюуны ирээдүй" цогцолбор сургууль нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 124 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг БШУГ-ын даргын 2024 оны 1 дүгээр сарын 26-ны А/03 тоот тушаалаар 95.6 хувиар биелүүлсэн гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	352,010,682.49	1,009,706,760.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	76,633,864.94	647,929,047.94
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	76,633,864.94	647,929,047.94
31210	Төгрөг	76,633,864.94	647,929,047.94
31211	Төрийн сангийн харилцах	76,633,864.94	647,929,047.94
35	БАРАА МАТЕРИАЛ	275,376,817.55	361,777,712.40
35100	Түүхий эд материал	2,878,856.00	2,494,494.00
35130	Эм боох материал	2,878,856.00	2,494,494.00
35400	Хангамжийн материал	272,497,961.55	359,283,218.40
35410	Бичиг хэргийн материал	8,832,072.00	2,866,480.00
35420	Аж ахуйн материал	35,820,722.55	35,461,049.95
35450	Барилгын засварын материал	338,000.00	54,325,911.20
35470	Бусад хангамжийн материал	227,507,167.00	266,629,777.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,024,379,130.48	13,294,515,939.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,024,379,130.48	13,294,515,939.30
39200	Биет хөрөнгө	10,760,725,103.65	11,030,031,977.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,543,893,735.37)	(1,943,020,820.29)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	920,593,081.34	1,759,391,081.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	(338,684,338.69)	(523,825,505.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	441,422,667.89	555,749,621.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(191,794,956.48)	(255,685,513.73)
39214	Бусад үндсэн хөрөнгө	323,662,433.78	323,662,433.78
39215	Хуримтлагдсан элэгдэл	(166,428,004.56)	(207,695,627.98)
39217	Ном	115,123,970.01	120,732,321.63
39300	Биет бус хөрөнгө	2,263,654,026.83	2,264,483,961.72
39301	Програм хангамж	14,024,300.00	17,483,572.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,170,273.17)	(5,799,610.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,252,800,000.00	2,252,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,376,389,812.97	14,304,222,699.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	33,316,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	33,316,500.00
41300	Өглөг	0.00	33,316,500.00
41360	Бусад өглөг	0.00	33,316,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	33,316,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,376,389,812.97	14,270,906,199.64
51	Засгийн газрын хувь оролцоо	13,376,389,812.97	14,270,906,199.64
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,200,550,188.95	4,200,550,188.95
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,200,550,188.95	4,200,550,188.95
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,121,632,909.96)	(227,116,523.29)
51210	Өмнөх үеийн үр дүн	(14,498,022,722.93)	(1,121,632,909.96)
51220	Тайлант үеийн үр дүн	13,376,389,812.97	894,516,386.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,297,472,533.98	10,297,472,533.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,376,389,812.97	14,304,222,699.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	20,675,221,727.41	9,640,054,634.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,860,028,258.41	1,011,711,392.92
120	Нийтлэг татварын бус орлого	13,860,028,258.41	1,011,711,392.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	198,427,822.00	138,144,327.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	87,850,100.00	99,142,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,105,922.00	39,002,027.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	46,471,800.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	13,376,426,408.50	624,030,526.02
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	285,174,027.91	249,536,539.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,815,193,469.00	8,628,343,241.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,486,871,400.00	8,389,438,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,486,871,400.00	8,389,438,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,822,194.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,822,194.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	319,499,875.00	238,904,841.68
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	319,499,875.00	238,904,841.68
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,273,894,406.39	8,710,455,081.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,273,894,406.39	8,710,455,081.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,649,825,915.77	8,106,561,662.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,822,439,557.00	5,923,337,588.00
210101	Үндсэн цалин	2,955,232,313.00	3,725,639,830.00
210102	Нэмэгдэл	1,526,590,080.00	1,989,381,289.00
210104	Урамшуулал	251,137,842.00	208,316,469.00
210105	Гэрээт ажлын хөлс	89,479,322.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	601,181,274.00	746,854,200.00
210201	Тэтгэврийн даатгал	409,426,935.00	508,239,464.00
210202	Тэтгэмжийн даатгал	48,277,887.00	60,527,247.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	38,017,867.00	47,448,761.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,357,516.00	11,718,151.00
210205	Эрүүл мэндийн даатгал	96,101,069.00	118,920,577.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,731,990.38	227,904,841.68
210301	Гэрэл, цахилгаан	43,566,101.63	48,846,835.28
210302	Түлш, халаалт	97,928,624.27	122,945,724.64
210303	Цэвэр, бохир ус	41,237,264.48	56,112,281.76
2104	Хангамж, бараа материалын зардал	2,041,265.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,131,660.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	909,605.00	0.00
2105	Нормативт зардал	43,102,744.50	57,853,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,927,469.50	0.00
210502	Хоол, хүнс	41,175,275.00	57,853,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,806,862.00	154,523,928.80
210604	Урсгал засвар	43,806,862.00	154,523,928.80

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,212,077.36	56,222,453.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,512,900.00	16,193,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,699,177.36	40,029,253.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	910,310,145.53	939,865,250.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	187,909,586.30	160,907,958.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,513,089.26	83,866,689.65
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	649,887,469.97	695,090,602.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	624,068,490.62	603,893,419.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	621,299,400.00	603,229,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	521,382,000.00	499,603,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	99,917,400.00	103,625,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,769,090.62	664,419.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,769,090.62	664,419.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	13,401,327,321.02	929,599,553.24
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,937,508.05	35,083,166.57
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	24,937,508.05	0.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	35,083,166.57
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	13,376,389,812.97	894,516,386.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,967,149,491.00	8,766,487,568.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	151,956,022.00	138,144,327.00
120	Нийтлэг татварын бус орлого	151,956,022.00	138,144,327.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	151,956,022.00	138,144,327.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	87,850,100.00	99,142,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,105,922.00	39,002,027.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,815,193,469.00	8,628,343,241.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,486,871,400.00	8,389,438,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,486,871,400.00	8,389,438,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,822,194.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,822,194.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	319,499,875.00	238,904,841.68
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	319,499,875.00	238,904,841.68
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,614,209,726.06	7,852,228,833.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,614,209,726.06	7,852,228,833.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,990,141,235.44	7,247,758,614.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,822,439,557.00	5,923,337,588.00

210101	Үндсэн цалин	2,955,232,313.00	3,725,639,830.00
210102	Нэмэгдэл	1,526,590,080.00	1,989,381,289.00
210104	Урамшуулал	251,137,842.00	208,316,469.00
210105	Гэрээт ажлын хөлс	89,479,322.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	601,181,274.00	746,854,200.00
210201	Тэтгэврийн даатгал	409,426,935.00	508,239,464.00
210202	Тэтгэмжийн даатгал	48,277,887.00	60,527,247.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	38,017,867.00	47,448,761.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,357,516.00	11,718,151.00
210205	Эрүүл мэндийн даатгал	96,101,069.00	118,920,577.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,731,990.38	227,904,841.68
210301	Гэрэл, цахилгаан	49,657,746.91	48,846,835.28
210302	Түлш, халаалт	91,836,978.99	122,945,724.64
210303	Цэвэр, бохир ус	41,237,264.48	56,112,281.76
2105	Нормативт зардал	41,175,275.00	57,276,600.00
210502	Хоол, хүнс	41,175,275.00	57,276,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,799,719.00	25,986,960.00
210604	Урсгал засвар	43,799,719.00	25,986,960.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,961,609.36	61,704,853.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,512,900.00	18,976,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,448,709.36	42,728,653.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	245,851,810.70	204,693,572.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	186,154,636.70	130,455,758.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	59,697,174.00	74,237,814.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	624,068,490.62	604,470,219.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	621,299,400.00	603,805,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	521,382,000.00	500,179,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	99,917,400.00	103,625,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,769,090.62	664,419.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,769,090.62	664,419.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	352,939,764.94	914,258,735.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	276,305,900.00	342,963,552.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	276,305,900.00	342,963,552.00
2200	Дотоод эх үүсвэрээр	276,305,900.00	342,963,552.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	276,305,900.00	342,963,552.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(276,305,900.00)	(342,963,552.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	76,633,864.94	571,295,183.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	76,633,864.94
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	76,633,864.94	647,929,047.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,200,550,188.95	10,297,472,533.98	(14,498,022,722.93)	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(14,498,022,722.93)	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	13,376,389,812.97	13,376,389,812.97
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(1,121,632,909.96)	13,376,389,812.97
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(1,121,632,909.96)	13,376,389,812.97
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(1,121,632,909.96)	13,376,389,812.97
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	894,516,386.67	894,516,386.67
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(227,116,523.29)	14,270,906,199.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,844,610,200.00	8,194,527,966.68	(650,082,233.32)	92.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,844,610,200.00	8,194,527,966.68	(650,082,233.32)	92.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,147,260,800.00	7,590,722,166.68	(556,538,633.32)	93.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,383,231,000.00	5,923,337,588.00	(459,893,412.00)	92.80
210101	Үндсэн цалин	4,397,088,100.00	3,725,639,830.00	(671,448,270.00)	84.73
210102	Нэмэгдэл	1,729,028,400.00	1,989,381,289.00	260,352,889.00	115.06
210104	Урамшуулал	257,114,500.00	208,316,469.00	(48,798,031.00)	81.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	797,903,700.00	746,854,200.00	(51,049,500.00)	93.60
210201	Тэтгэврийн даатгал	542,574,500.00	508,239,464.00	(34,335,036.00)	93.67
210202	Тэтгэмжийн даатгал	63,832,300.00	60,527,247.00	(3,305,053.00)	94.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,065,900.00	47,448,761.00	(3,617,139.00)	92.92
210204	Ажилгүйдлийн даатгал	12,766,400.00	11,718,151.00	(1,048,249.00)	91.79
210205	Эрүүл мэндийн даатгал	127,664,600.00	118,920,577.00	(8,744,023.00)	93.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,962,300.00	227,904,841.68	(57,458.32)	99.97
210301	Гэрэл, цахилгаан	52,251,200.00	48,846,835.28	(3,404,364.72)	93.48
210302	Түлш, халаалт	126,328,900.00	122,945,724.64	(3,383,175.36)	97.32
210303	Цэвэр, бохир ус	49,382,200.00	56,112,281.76	6,730,081.76	113.63
2105	Нормативт зардал	66,239,600.00	57,276,600.00	(8,963,000.00)	86.47
210502	Хоол, хүнс	66,239,600.00	57,276,600.00	(8,963,000.00)	86.47
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,000,000.00	62,573,160.00	(426,840.00)	99.32
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00	0.00	100.00
210602	Тавилга	19,000,000.00	18,586,200.00	(413,800.00)	97.82
210604	Урсгал засвар	26,000,000.00	25,986,960.00	(13,040.00)	99.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,608,900.00	70,472,353.00	(1,136,547.00)	98.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,980,200.00	18,976,200.00	(4,000.00)	99.98
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	52,628,700.00	51,496,153.00	(1,132,547.00)	97.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	537,315,300.00	502,303,424.00	(35,011,876.00)	93.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	458,221,600.00	423,209,724.00	(35,011,876.00)	92.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,093,700.00	79,093,700.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	697,349,400.00	603,805,800.00	(93,543,600.00)	86.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	697,349,400.00	603,805,800.00	(93,543,600.00)	86.59
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	593,723,500.00	500,179,900.00	(93,543,600.00)	84.24
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	103,625,900.00	103,625,900.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,844,610,200.00	8,765,823,149.68	(78,787,050.32)	99.11
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,389,438,400.00	8,389,438,400.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	8,389,438,400.00	8,389,438,400.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	238,962,300.00	238,240,422.68	(721,877.32)	99.70
320001	Орон нутгийн төсвөөс	238,962,300.00	238,240,422.68	(721,877.32)	99.70
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	216,209,500.00	138,144,327.00	(78,065,173.00)	63.89
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	104,980,200.00	99,142,300.00	(5,837,900.00)	94.44
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,595,700.00	39,002,027.00	4,406,327.00	112.74
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	76,633,600.00	0.00	(76,633,600.00)	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	76,633,864.94	76,633,864.94	1.00

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	647,929,047.94	647,929,047.94	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	281.00	275.00	(6.00)	1.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	240.00	238.00	(2.00)	1.00
620003	Үйлчлэх ажилтан	40.00	36.00	(4.00)	1.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	5,398.00	5,395.00	(3.00)	1.00
630001	Төрийн өмчит ЕБС	5,398.00	5,395.00	(3.00)	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 173,727.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 142,248.7 мянган төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 387.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 31,091.9 мянган төгрөгийн дахин давтан гаргахгүй байх 5 зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитын явцад дараах Алдаануудыг залруулсан. Үүнд:

- 210801 зардлын дансанд тооцооны дансаар дамжуулан гүйлгээ хийгээгүй 16,193.2 мянган төгрөгийн 9 гүйлгээ,
- 210901 зардлын дансанд тооцооны дансаар дамжуулан гүйлгээ хийгээгүй 70,777.0 мянган төгрөгийн 109 гүйлгээ,
- 210806 зардлын дансанд тооцооны дансаар дамжуулан гүйлгээ хийгээгүй 26,534.5 мянган төгрөгийн 16 гүйлгээ,
- 210101 зардлын дансанд тооцооны дансаар дамжуулан гүйлгээ хийгээгүй 153.6 мянган төгрөгийн 1 гүйлгээ,
- 210902 зардлын дансанд тооцооны дансаар дамжуулан гүйлгээ хийгээгүй 250.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ,
- Үнэ төлбөргүй шилжүүлэн авсан засварын материалын баталгааг болох 1,250.0 мянган төгрөгийг бараа материалын дансаар дамжуулан бүртгэсэн,
- Бараа материалын 35450 тоот дансанд 3,286.4 мянган төгрөгийн баталгаажуулалтын төлбөр, цэвэрлэгээний төлбөрийг орлогоор бүртгэсэн,
- Бараа материалын 35410 тоот дансанд 2,454.0 мянган төгрөгийн техникийн нөхцөлийн төлбөр, сургалтын замын зардлыг орлогоор бүртгэсэн авсан,
- БШУЯ-ны санхүүжилтээр хийгдсэн 21,350.0 мянган төгрөгийн засварын зардлыг үндэслэх баримтгүйгээр бараа материалын 35450 тоот дансанд 21,350.0 төгрөгөөр орлого авч бүртгэсэн зардлаар бүртгэсэн.

Санхүүгийн тайланг нийт 142,248.7 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 "Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулав.

3.1 Төлбөрийн акт

1. Цалингийн тооцоолол, цагийн бүртгэлийг дахин хянаагүйгээс 4 ажилтанд баталгаажуулсан цагийн балансаас илүү цагаар тооцож, 387.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ерөнхий нягтлан бодогч Т.Должинсүрэн, тооцооны нягтлан бодогч Э.Ариунцэцэг, нярав С.Бадам-очир, нярав Д.Оюунчимэг нарт БШУЯ-ны 2/3151 тоот албан бичгийг үндэслэн захирлын 2023 оны 07 сарын 03-ны өдрийн А/48 тоот тушаалаар 8,106.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан цалингийн сангаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 4.8.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно, улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн тооцох урамшууллын хэмжээг энэ журмын 4.5-д заасан аргачлалд тусгана" гэсэн заалтыг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Багш Б.Саранчимэгт 2022 оны 4 дүгээр улирлын үнэлгээний үр дүнгийн урамшууллыг 2023 оны төсвийн жилд нөхөж 452.3 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д " хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7.1-д "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 7.6-д "Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", НББ-ийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын тайлан, орлого зарлагын гүйлгээг түүвэрлэн шалгахад 61 нэр төрлийн 13,315.3 мянган төгрөгийн аж ахуйн болон цэвэрлэгээний материалын орлогыг бүртгэхдээ бичиг хэргийн материалын дансанд бүртгэн, зарцуулалт хийн оны эцэст тухайн дансанд 468.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна, БШУЯ-ны санхүүжилтээр хийгдсэн 6,635.9 мянган төгрөгийн цахим анги тохижуулахад дагалдаж ирсэн цаашид ашиглах боломжтой бусад аж ахуйн шинж чанартай материалуудыг үндэслэх баримтгүйгээр бараа материалыг 35470 тоот дансанд орлого авч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9. "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 4.16 "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө", 2021 оны 12 сарын 27 өдрийн сургуулийн захирлын А/23 тоот тушаалаар баталсан НБББББ-ын бараа материалын бүртгэлийн горим нь "Материаллаг

нөөцийн худалдан авалт, зарцуулалт болон үлдэгдлийн өртгийг зөв тооцох, бараа материалтай холбоотой ажил гүйлгээ гарсныг нотлох, баримтжуулах, хянаж зөвшөөрөх, үнэн зөв ангилж бүртгэлд тусгах тайлагнах, зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулахад чиглэгдэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн ба “Үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Тайлант оны эцсийн үлдэгдлээр 16 нэр төрлийн 468,5 мянган төгрөгийн аж ахуйн материалыг дансны дотоод гүйлгээгээр шилжүүлэн бүртгэх, цахим ангид ашиглах бусад хангамжийн материалын нэг бүрийн үнийг дахин тогтоох зөвлөмж хүргүүлэх.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээг түүвэрлэн шалгахад 29 нэр төрлийн 15,429.2 мянган төгрөгийн хөрөнгийг дансны ангилал буруу бүртгэн орлого авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9. “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 4.29 “Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ыг дагаж мөрдөнө.”, 2021 оны 12 сарын 27 өдрийн сургуулийн захирлын А/23 тоот тушаалаар баталсан НБББББ-ын бараа материалын бүртгэлийн горим нь “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн горим нь үндсэн хөрөнгийн ажил гүйлгээнүүдийг баримтжуулах, үндэслэлтэй, үнэн зөв бүртгэлд тусгах, тайлагнах, хөрөнгийн ашиглалтад хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулахад чиглэгдэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн ба “Үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Үндсэн хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, элэгдлийн тооцооллыг давтан шалгах, зөвлөмж хүргүүлэх.

5. Үндсэн хөрөнгө бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллогын тайланг хянан шалгахад дараах зөрчил ажиглагдаж байна. Үүнд жилийн эцсийн тооллогын үр дүнг 12 сарын 31-ний үлдэгдлээр тохируулдаггүй, тооллогын илтгэх хуудас болон тайланг үндсэн хөрөнгө, бараа материалын ангилал тус бүрээр дэлгэрэнгүй бодитой бичдэггүй, тооллогын хуудсыг батлагдсан маягтын дагуу бэлтгэдэггүй, санхүүгийн программаас үлдэгдлийг хуулж бичдэг, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, тооллогын комиссын тайлан мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж дүгнэлт гаргаагүй, тооллого хийсэн протокол нь тооллогын шаардлагад нийцэхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна”, 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн тогтоосон хугацаанд явуулж, улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнах”, 72.4-д “Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтад нийцэхгүй байна. гэсэн заалтуудыг зөрчсөн ба “Үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж байх, үндсэн хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, элэгдлийн тооцооллыг давтан шалгах, зөвлөмж хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тооцооны дансаар дамжуулан хийгээгүй.	1	16,193.2					1	16,193.2				
Тооцооны дансаар дамжуулан хийгээгүй.	1	26,534.5					1	26,534.5				
Тооцооны дансаар дамжуулан хийгээгүй.	1	70,777.0					1	70,777.0				
Тооцооны дансаар дамжуулан хийгээгүй.	1	153.6					1	153.6				
Тооцооны дансаар дамжуулан хийгээгүй.	1	250.0					1	250.0				
Үнэ төлбөргүй шилжүүлэн ирсэн орлогыг 1,250.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн	1	1,250.0					1	1,250.0				
Зардалд бүртгэл хийх	1	3,286.4					1	3,286.4				
Зардалд бүртгэл хийх	1	2,454.0					1	2,454.0				
Зардалд бүртгэл хийх	1	21,350.0					1	21,350.0				
	9	142,248.7	0	0	0	0	9	142,248.7	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын ангилал буруу хийгдсэн байна.	1	7,104.4					1	7,104.4				
Үндсэн хөрөнгийн орлогын бүртгэл хийхдээ НББББ баримт мөрдөөгүй, дансны ангилал буруу бүртгэсэн	1	15,429.2					1	15,429.2				

2023 оны үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийсэн хэдий ч тооллогын үр дүнг дүгнээгүй, тайлан мэдээг бүрэн гаргаагүй, өмч хамгаалах байнгын зөвлөл хурал хийж үр дүнг тайлагнаагүй	1	0.00					1	0.00			
Балансын урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан цалингийн зардлаас олгосон.	1	8,106.0					1	8,106.0			
Үнэлгээний хувь хэмжээг буруу тооцон 1 ажилтанд үр дүнгийн урамшуулал илүү олгосон.	1	452.3					1	452.3			
Цалингийн тооцоолол, цагийн бүртгэлийг дахин хянаагүйгээс 4 ажилтанд цалин илүү олгосон.	1	387.0	1	387.0							
	6	31,478.9	1	387.01			5	31,091.9			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 909,042.7 мянган төгрөгийн 18 гүйлгээ, 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 16,505.0 мянган төгрөгийн 3 шийдвэр тус тус мэдээлээгүй байна.	1	925,547.7					1	925,547.7
Дүн	1	925,547.7					1	925,547.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	925,547.7					1	925,547.7